

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Гүйцэтгэлийн аудитын алба



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**АЙМАГ СУМДЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХТАЙ ХОЛБОГДСОН УЛСЫН
ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛСЭН ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
АУДИТЫН ТАЙЛАН**

АУДИТЫН КОД:УАГ-ХОА/2020/-02-ГА

Ховд хот
2020 оны 11 сар

Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд
Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар
Утас: 99047408 Цахим хаяг: Boldbaatar.khu@audit.gov.mn
Хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер: А.Цэцэгсүрэн
Утас:99013699 Цахим хаяг:tsetsegsuren.a@audit.gov.mn
Ахлах аудитор: Д.Нарантуул
Утас:7043-2545 Цахим хаяг: : narantuuld@audit.gov.mn
Ахлах аудитор: Д.Мөнхтулга
Утас:7043-2545 Цахим хаяг: : munkhtulga.d@audit.gov.mn
Аудитор: -Д.Балжинням
Утас:7043-2545 Цахим хаяг:baljinnyamd@audit.gov.mn

| | | |
|---|--|----|
| Аудитыг гүйцэтгэж тайланг бэлтгэсэн: | Товчилсон үгийн жагсаалт Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй стандартын талаарх мэдэгдэл | 4 |
| ҮАГ-ын харьяа Ховд аймаг дахь аудитын газар | | |
| Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор | Бүлэг 1 Улсын төсвөөс олгох санхүүжилтийг СЕХ-оос ирүүлсэн аргачлалын дагуу хуваарилан өмнөх зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан байна. | 5 |
| Х.Болдбаатар | 1.1 Аймгийн сонгуулийн хороонд улсын төсвөөс 485.5 сая төгрөгийг хуваарилжээ. | 5 |
| Утас: 70433061 | 1.2 Аймгийн сонгуулийн хороо нь хэсгийн хороодод олгох төсвийг СЕХ- ноос ирүүлсэн аргачлалын дагуу хуваарилсан байна. | 5 |
| Хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер | 1.3 Улсын бүртгэлийн Ерөнхий газраас сонгууль зохион байгуулах зардлыг бодиттой төлөвлөснөөр 23.2 сая төгрөгийн хэмнэлт бий болжээ. | 6 |
| А.Цэцэгсүрэн | 1.4 ОБЕГ-аас олгосон бараа материалыг төлөвлөсний дагуу Аймгийн Сонгуулийн хороонд хуваарилсан байна. | 6 |
| Утас 99013699 | | |
| Ахлах аудитор | | |
| Д.Нарантуул | Бүлэг 2. Батлагдсан төсвийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан ч төсвийн зарцуулалтад тавих дотоод хяналтыг сайжруулан ажиллах шаардлагатай байна. | 7 |
| Утас: 99019800 | | |
| Д.Мөнхтулга | 2.1 Аймаг, сумдын ИТХ-ын сонгуулийн зардалд 484.5 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна. | 7 |
| Утас: 99031809 | 2.2 Зарим хэсгийн хороодын анхан шатны баримтын бүрдүүлэлт бүрэн бус байна. | 8 |
| Аудитор Д.Балжинням | 2.3 Улсын бүртгэлийн хэлтэс сонгуулийн зардлыг холбогдох хууль, журмыг мөрдөж зарцуулжээ. | 9 |
| Утас: 99435309 | 2.4 Засгийн газрын нөөц хөрөнгөөс хуваарилсан бараа материалыг зориулалтын дагуу зарцуулсан ч зарцуулаагүй үлдээдлийг холбогдох газарт хүлээлгэн өгч ашиглах шаардлагатай байна. | 9 |
| | 2.5 Хөрөнгийн зарцуулалтад тавих дотоод хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүй байна. | 10 |
| | Дүгнэлт: | 10 |
| | Аудитын зөвлөмж | 10 |
| | Тэргүүлэх Аудиторын тушаал | 12 |
| | Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал: | 13 |
| 2020 оны 11 дүгээр сар | | |
| Уг тайланг ҮАГ-ын Веб сайтаас үзнэ үү. www.audit.gov.mn | | |
| Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70432545 дугаарын утас, 70433061 дугаарын факсаар харилцана уу. | | |
| ХАЯГ: Ховд аймгийн Засаг даргын Тамгын газар Ховд аймаг дахь Төрийн Аудитын газар 3 давхар | | |

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---------------|---|
| АДБОУС | Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт |
| УИХ | Улсын их хурал |
| ЗГ | Засгийн газар |
| ҮАГ | Үндэсний Аудитын газар |
| ИТХ | Иргэдийн төлөөлөгчдийн хурал |
| СЕХ | Сонгуулийн ерөнхий хороо |
| УБХ | Улсын бүртгэлийн хэлтэс |
| ОБЕГ | Онцгой байдлын ерөнхий газар |
| ХХОАТ | Хувь хүний орлогын албан татвар |
| БҮТЭЗ | Бага үнэтэй түргэн элэгдэх зүйл |

1.1. Аудит хийх бүрэн эрх, үндэслэл: Аудитыг Монгол Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны 2020 оны аудитын сэдэв батлах тухай 04 дүгээр тогтоол, Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/53 дугаар тушаалаар баталсан Үндэсний Аудитын газрын 2020 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуульд заасны дагуу Ховд аймаг Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

1.2 Аудитын зорилт: Аймаг сумдын ИТХ-ын 2020 оны ээлжит сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн гүйцэтгэлд дүгнэлт гаргаж, зөвлөмж боловсруулан Аймгийн ИТХ, Засаг дарга, Аймгийн сонгуулийн хороо, холбогдох байгууллагуудад танилцуулж, иргэд, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэнэ.

Аудитын зорилтыг ханган биелүүлэхийн тулд дараах чиглэлээр аудит хийнэ.

- Аймаг сумдын ИТХ-ын сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг хууль, журам, зориулалтын дагуу төлөвлөж, хуваарилсан эсэх
- Аймаг сумдын ИТХ-ын зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг арвилан хэмнэлттэй зарцуулсан эсэх

1.3 Аудитын хамрах хүрээ: Аудитад аймаг, сумдын сонгуулийн хороо, аймгийн улсын бүртгэлийн хэлтсийн үйл ажиллагаанд улсын төсвөөс олгосон зардлын гүйцэтгэлийг хамрууллаа. Аймгийн Цагдаагийн газарт улсын төсвөөс олгосон санхүүгийн анхан шатны баримтыг Цагдаагийн Ерөнхий газарт хүргүүлсэн, Онцгой байдлын газраас ирүүлсэн бараа материалыг Аймгийн сонгуулийн хороонд хүлээлгэн өгсөн тул аудитад хамруулаагүй болно.

1.4 Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт: Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 100, АДБОУС 400, АДБОУС 3000 дугаар стандартууд, Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын журмыг баримтлан Аймаг, сумдын сонгуулийн хорооны холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, судалгаа авч шинжилгээ хийх, санхүүгийн тайлан, анхан шатны баримт, ажлын төлөвлөгөө, тайлантай тулган баталгаажуулах арга зүйг ашиглан аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох бусад мэдээллийг ажлын баримт материалд хавсаргав.

Аудитад Төсвийн тухай хууль, Татварын тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Сонгуулийн тухай хууль, Аймаг, нийслэл, сум дүүргийн ИТХ-ын сонгуулийн тухай хууль, Сонгуулийн ерөнхий хорооноос гаргасан эрх зүйн актууд,

Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн: Аудитыг газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар удирдан, аудитын менежер А.Цэцэгсүрэн аудитын арга зүйгээр хангаж, үе шатны болон чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Д.Нарантуул Д.Мөнхтулга аудитор Д.Балжинням нар гүйцэтгэв.

Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдах мэдээлэл: Аудитын тайлангийн I бүлэгт сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг хууль, журам, зориулалтын дагуу төлөвлөж, хуваарилсан эсэх, II бүлэгт Сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг арвилан хэмнэлттэй зарцуулсан эсэх талаар тайлагнаж ерөнхий зүйл, аудитын дүн, аудитын дүгнэлт, зөвлөмж, холбогдох газрын санал гэсэн агуулгаар бичлээ.

Бүлэг 1: Улсын төсвөөс олгох санхүүжилтийг СЕХ-оос ирүүлсэн аргачлалын дагуу хуваарилан өмнөх зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан байна.

Аймгийн сонгуулийн хороонд улсын төсвөөс 485.6 сая төгрөгийг хуваарилжээ.

1.1 Аймаг, нийслэл, сум дүүргийн ИТХ-ын сонгуулийн тухай хуулийг 2020 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр батлан, 2020 оны 02 дугаар сарын 14-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсөн байна. Ховд аймгийн Сонгуулийн хороог СЕХ-ны 2020 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн 137 тоот тогтоолоор 9 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулжээ. Аймгийн сонгуулийн хороо нь 17 сумдын сонгуулийн хороог 2020 оны 08 дугаар сарын 13-ны өдрийн 02 тоот тогтоолоор 115 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулжээ. Харьяалагдах нутаг дэвсгэрийн хэмжээнд 17 сумын 91 хэсгийн хороотойгоор нийт 895 төрийн албан хаагч ажиллаж СЕХ-оос 485.6 сая төгрөгийн санхүүжилтийг авсан байна.

1.2 Аймаг, нийслэл, сум дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуульд нийт 53841 сонгогч бүртгэгдсэнээс 33800 сонгогч саналаа өгч 62.75 хувийн ирцтэй оролцжээ.

1.3 Аймгийн сонгуулийн хороо нь аймаг, нийслэл, сум дүүргийн ИТХ -ын ээлжит сонгуулийг зохион байгуулах, сумдын сонгуулийн хороог байгуулах, арга зүйгээр хангах чиг үүрэгтэйгээр үйл ажиллагаагаа явуулжээ.

Аймгийн сонгуулийн хороо нь хэсгийн хороодод олгох төсвийг СЕХ-ноос ирүүлсэн аргачлалын дагуу хуваарилсан байна.

1.4 Аймаг, нийслэл, сум дүүргийн ээлжит сонгууль зохион байгуулахтай холбоотойгоор СЕХ-оос аймгийн Сонгуулийн хороонд 485.6 сая төгрөгийн санхүүжилтийг хуваарилж гүйцэтгэлээр 484.5 сая төгрөгийн зардал санхүүжүүлж 1.1 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийг төсөвт буцаан төвлөрүүлжээ.

1.5 Сонгууль зохион байгуулахтай холбоотой зардлыг сумдын сонгуулийн хороонд хуваарилахдаа хэсгийн тоо болон ажиллах хүний тоо, сонгогчдын тоо газар нутгийн хэмжээг үндэслэжээ. Аймгийн сонгуулийн хороо нь СЕХ-оос ирүүлсэн зөвлөмжийн дагуу холбогдох зардлуудыг сумдын сонгуулийн хороонд хуваарилсан бөгөөд нийт төсвийн 88.1 хувь буюу 427.8 сая төгрөгийг хуваарилжээ.

Дүрслэл 1



Улсын бүртгэлийн Ерөнхий газраас сонгууль зохион байгуулах зардлыг бодиттой төлөвлөснөөр 23.2 сая төгрөгийн хэмнэлт бий болжээ.

1.7 Улсын бүртгэлийн Ерөнхий газраас аймгийн УБХ-д УИХ-ын сонгууль зохион байгуулахад 92.0 сая төгрөг баталж олгосон бол аймаг сумдын ИТХ-ын 2020 оны ээлжит сонгууль зохион байгуулахад 68.8 сая төгрөгийг баталжээ. Хүснэгт 1

| Зардлын үзүүлэлт | УИХ-ын сонгуулиар батлагдсан | Аймаг, сумдын ИТХ-ын сонгуулиар батлагдсан | Зөрүү |
|--|------------------------------|--|-------|
| Мөнгөн урамшуулал | 55.6 | 43.6 | -12 |
| Сонгогчдын нэрийн жагсаалт хэвлэх бичиг хэргийн зардал | 6.3 | 4.8 | -1.5 |
| Сургалт зохион байгуулах | 19.7 | 11.9 | -7.8 |
| Техник хэрэгсэл тээвэрлэх болон шуурхай багийн зардал | 10.4 | 8.5 | -1.9 |
| Нийт дүн | 92 | 68.8 | -23.2 |

УИХ-ын 2020 оны ээлжит сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэлд хийгдсэн аудитаар аймгийн УБХ-т өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласаар дараах зардлууд бодитой төлөвлөгдөж, санхүүгийн бодит хэмнэлт бий гарсан байна. Үүнд:

- Аймгийн УБХ-ийн мэргэжилтнүүдэд итгэмжлэгдсэн ажилтны урамшууллыг давхардуулан олгохоор төлөвлөж байсныг зогсоож 12.0 сая төгрөгийн төсвийг хэмнэсэн,
- Жаргалант сумын итгэмжлэгдсэн ажилтнуудад томилолт олгодог байдлыг зогсоож төсвийг 7.8 сая төгрөгөөр хэмнэсэн,
- Бичиг хэргийн зардлыг сумдын хэсгийн хороодын тоонд үндэслэн төлөвлөсөнтэй холбоотойгоор 1.5 сая төгрөг,
- Техник хэрэгсэл тээвэрлэх болон шуурхай багийн зардал 1.9 сая, нийт 23.2 сая төгрөг хэмнэгджээ.

ОБЕГ-аас олгосон бараа материалыг төлөвлөсний дагуу Аймгийн Сонгуулийн хороонд хуваарилсан байна.

1.8 Аймаг, сумдын ИТХ-ын сонгууль зохион байгуулахад Ковид-2019 цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор ариутгалын нэг удаагийн цаасан бээлий 44674 хос, гар ариутгагч 538 ширхэг, сонгуулийн ажилтны резин бээлий 2637 хосыг тус тус ОБЕГ-ын харьяа 185-р салбараас аймгийн сонгуулийн хороонд шилжүүлж, нийт сонгогчдын 75 хувьд олгохоор хуваарилсан байна.

Бүлэг 2: Батлагдсан төсвийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан ч төсвийн зарцуулалтад тавих дотоод хяналтыг сайжруулан ажиллах шаардлагатай байна.

Аймаг, сумдын ИТХ-ын сонгуулийн зардалд 484.5 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

2.1 Аймгийн 91 сонгуулийн хороонд 911 гишүүд, мэдээлэл технологийн ажилтан ажиллаж 484.5 сая төгрөгийн төсвийг зарцуулан СЕХ-оос өгсөн зөвлөмж, аргачлалын дагуу төсвийг хуваарилан зарцуулжээ.

2.2 Аймаг, нийслэл, сум дүүргийн ээлжит сонгууль зохион байгуулахтай холбогдон улсын төсвөөс 485.6 сая төгрөгийн санхүүжилт олгож, гүйцэтгэлээр 484.5 сая төгрөг зарцуулж, 1.1 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг Сонгуулийн Ерөнхий хорооны дансанд төвлөрүүлсэн байна. Сонгуулийн зардлын гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 2

| № | Зардлын нэр | Батлагдсан төсөв / сая.төг/ | Гүйцэтгэл /сая.төг/ | Зөүү |
|----------|---|--------------------------------|------------------------|------|
| 1 | Тогтоол, протокол, бусад маягт хэвлүүлэх зардал | 0.3 | 0.3 | - |
| 2 | Үнэмлэх хэвлэх зардал | 2.5 | 2.5 | - |
| 3 | Сургалтын зардал | 16.6 | 16.6 | - |
| 4 | Бичиг хэргийн зардал | 10.6 | 10.6 | - |
| 5 | Шуудан холбооны зардал | 12.7 | 12.7 | - |
| 6 | Унааны зардал | 48.2 | 47.1 | 1.1 |
| 7 | Санал авах байр, Төрийн далбаа бэлтгэх зардал | 20.0 | 20.0 | - |
| 8 | Сурталчилгааны зардал | 8.0 | 8.0 | - |
| 9 | Саналын хуудас, ИСР төхөөрөмж авах, хүлээлгэн өгөх зардал | 33.2 | 33.2 | - |
| 10 | МТБ-ийн зардал | 0.7 | 0.7 | - |
| 11 | Сонгуулийн автоматжуулсан системийн зардал /Эрчим хүчний эх үүсвэр бэлтгэх/ | 3.2 | 3.2 | - |
| 12 | Томилолтын зардал | 11.2 | 11.2 | - |
| 13 | Унааны зардал/туршилтын болон санал авах өдрийн мэдээ дамжуулах/ | 3.6 | 3.6 | - |
| 14 | Болзошгүй зардал | 7.4 | 7.4 | - |
| 15 | Аймаг, сум, хэсгийн хорооны гишүүдийн урамшуулал хоолны зардал | 269.7 | 269.7 | - |
| 16 | МТТ-ийн багийн гишүүн, санал авах байрны даамлын урамшуулал, хоолны зардал | 37.8 | 37.8 | - |
| НИЙТ ДҮН | | 485.6 | 484.5 | 1.1 |

2.3 Аймаг, сумдын сонгуулийн хороо нь аймгийн Сонгуулийн хорооноос өгсөн аргачлал, зөвлөмжийн дагуу зардлыг санхүүжүүлж авлага, өр төлбөр үүсгээгүйгээр ажиллажээ. Нийт олгосон санхүүжилтийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 3

| Сонгуулийн хэсгийн хороодын нэрс | хэсгийн хорооны тоо | гишүүд, МТАжилтан | Төлөвлөгөө /сая.төг/ | Гүйцэтгэл /сая.төг/ | зөрүү |
|----------------------------------|---------------------|-------------------|----------------------|---------------------|-------|
| Алтай сум | 4 | 42 | 20.6 | 20.3 | 0.3 |
| Булган сум | 6 | 60 | 28.5 | 28.5 | 0 |
| Буянт сум | 5 | 50 | 24 | 24 | 0 |
| Дарви сум | 5 | 48 | 23.5 | 23.7 | -0.2 |
| Дуут сум | 4 | 40 | 19.5 | 19.7 | -0.2 |
| Дөргөн сум | 4 | 40 | 19.5 | 19.5 | 0 |
| Зэрэг сум | 5 | 48 | 23.5 | 23.5 | 0 |
| Жаргалант сум | 12 | 129 | 54.1 | 54.1 | 0 |
| Манхан сум | 6 | 56 | 27.1 | 27.1 | 0 |
| Мөнххайрхан сум | 4 | 40 | 19.7 | 19.9 | -0.2 |
| Мөст сум | 5 | 48 | 23.5 | 23.5 | 0 |
| Мянгад сум | 5 | 48 | 23.4 | 23.4 | 0 |
| Үенч сум | 5 | 48 | 23.6 | 23.6 | 0 |
| Ховд сум | 5 | 48 | 23.2 | 23.2 | 0 |
| Цэцэг сум | 5 | 46 | 22.8 | 22.8 | 0 |
| Чандмань сум | 6 | 56 | 27.3 | 26.3 | 1.0 |
| Эрдэнэбүрэн сум | 5 | 48 | 23.4 | 23.4 | 0 |
| Аймгийн сонгуулийн хороо | | 16 | 58.4 | 58 | 0.4 |
| Нийт дүн | 91 | 911 | 485.6 | 484.5 | 1.1 |

Зарим хэсгийн хороодын анхан шатны баримтын бүрдүүлэлт бүрэн бус байна.

2.4 Аймгийн сонгуулийн хороонд 58.4 сая төгрөгийн төсөв батлагдаж гүйцэтгэлээр 57.4 сая төгрөгийг зарцуулж, 0.4 сая төгрөгийн төсөв хэмнэн төвлөрүүлсэн байна. Зардлын гүйцэтгэлийг хянахад сонгуулийн байгууллагын 30 жилийн ойг угтаж сонгуулийн хороонд ажиллаж байсан үе үеийн хүмүүстэй уулзалт арга хэмжээ зохион байгуулахад 0.6 сая, хүнсний материал худалдан авахад 1.3 сая нийт 1.9 сая төгрөгөөр зардлыг зориулалт бусаар зарцуулсан байна.

2.5 Сумдын сонгуулийн хороонд 427.3 сая төгрөгийг хуваарилж гүйцэтгэлээр 427.9 сая төгрөгийг зарцуулснаас Алтай сум 0.3, Чандмань сум 1.0 бүгд 1.3 сая төгрөгийг аймгийн Сонгуулийн хорооны дансанд төвлөрүүлжээ. Аудитын хүрээнд сумдын сонгуулийн хороодын санхүүгийн баримтыг хянахад дараах алдаа зөрчил илэрлээ.

- *Буянт сумын сонгуулийн хорооны томилолтоор ажилласан гишүүн, мэдээлэл технологийн ажилчдад олгох томилолтын мөнгийг илүү, Цэцэг, Мөст, Эрдэнэбүрэн, Дарви сумдын сонгуулийн хороо нь онцгой, эрүүл мэндийн ажилтанд олгох хоолны мөнгөнөөс ХХОАТ суутгаагүй, Дарви сумын сонгуулийн хороо нь*

урамшуулал илүү олгосон, Эрдэнэбүрэн сумын сонгуулийн хороо нь сумын ИТХ-ын төлөөлөгчийн тэмдэг, үнэмлэх хавтас худалдан авч зориулалт бусаар зарцуулсан,

- Алтай, Булган, Буянт, Мянгад, Чандмань, Үенч, Дөргөн, Ховд, Цэцэг, Эрдэнэбүрэн, Дуут сумдын сонгуулийн хорооны гишүүд, мэдээлэл технологийн ажилтны томилолтоор ажилласан хугацааны томилолтын хуудсанд аймгийн сонгуулийн хорооны болон сумдын сонгуулийн даргаар гарын үсэг тамга дараагүй бүрэн томилолтын хуудсаар 7.4 сая төгрөгийн томилолтын зардал олгосон,
- Манхан сумын сонгуулийн хороо нь сургалт зохион байгуулах, хэсгийн хорооны байр тохижуулах, бичиг хэргийн материал худалдан авахад 1.6 сая төгрөгийг зарцуулсан ч анхан шатны баримтын бүрдэл бүрэн бус, Жаргалант, Манхан сумдын сонгуулийн хороод 0.7 сая төгрөгөөр хүнсний материал худалдан авахад зарцуулсан.
- Сумдын хэсгийн хороод нь байр тохижуулах зардлаас 6.7 сая төгрөгөөр БҮТЭЗ-ийг худалдан авч сумдын ИТХ-ын данс бүртгэлд бүртгэлд бүртгэсэн баримтгүй,
- Цэцэг, Манхан, Мянгад, Дөргөн, Буянт, Дарви, Жаргалант сумдын сонгуулийн хороод 6.0 сая төгрөгийн шатахууныг жолоочийн замын хуудсанд гарын үсэг зурж баталгаажуулаагүй, жолоочийн замын хуудасгүй, тооцоо бодоогүй, нормативаас илүү зарцуулсан зэрэг зөрчлүүд илэрлээ.

Улсын бүртгэлийн хэлтэс сонгуулийн зардлыг холбогдох хууль, журмыг мөрдөж зарцуулжээ.

2.6 Улсын бүртгэлийн байгууллагын ажилтан, итгэмжлэгдсэн ажилтны болон гэрээт ажилтны мөнгөн урамшуулал, хоол унааны зардалд 43.6 сая, сонгогчдын нэрийн жагсаалт хэвлэхэд шаардагдах бичиг хэргийн зардалд 4.8 сая, сургалт зохион байгуулах болон түүнтэй холбогдон гарах бусад зардалд 8.7 сая, сонгогчийг бүртгэх, таних техник хэрэгслийг тээвэрлэх болон техник хэрэгслийн хэвийн ажиллагааг хангаж ажиллах шуурхай багийн зардалд 11.7 сая нийт 68.8 сая төгрөгийн батлагдсан төсвийг зориулалтын дагуу, холбогдох хууль журмыг баримтлан зарцуулжээ.

Хүснэгт 4

| Зардлын нэр төрөл | Батлагдсан | | Зөрүү |
|--|--------------------|------------------------|----------|
| | төсөв /сая.төг/ | Гүйцэтгэл /сая.төг/ | |
| Мөнгөн урамшуулал | 43.6 | 43.6 | - |
| Сонгогчдын нэрийн жагсаалт хэвлэх бичиг хэргийн зардал | 4.8 | 4.8 | - |
| Сургалт зохион байгуулах | 11.9 | 10.7 | -1.2 |
| Техник хэрэгсэл тээвэрлэх болон шуурхай багийн зардал | 8.5 | 9.7 | 1.2 |
| Нийт дүн | 68.8 | 68.8 | - |

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн Жаргалант сумын итгэмжлэгдсэн ажилтнуудад сургалтын зардал олгоогүйгээс 1.2 сая төгрөгийг хэмнэж шуурхай багын зардалд зарцуулжээ.

Засгийн газрын нөөц хөрөнгөөс хуваарилсан бараа материалыг зориулалтын дагуу зарцуулсан ч зарцуулаагүй үлдэгдлийг холбогдох газарт хүлээлгэн өгч ашиглах шаардлагатай байна.

2.6 Орон нутгийн ИТХ-ын сонгууль зохион байгуулахад Ковид-2019 цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор ОБЕГ-аас ирүүлсэн бараа материалыг аймгийн сонгуулийн хороонд хүлээлгэн өгснийг сонгогчдын тоонд үндэслэн сонгуулийн хороодод хуваарилан олгожээ. Аймгийн сонгуулийн хороо, сумдын сонгуулийн хорооны зардлын тайланг нэгтгэхдээ сонгогчийн тооноос хамааран зарцуулаагүй бараа материалын үлдэгдлийг буцаан авч бүртгэл хөтөлж баталгаажуулжээ.

Аймаг, сумдын сонгуулийн хороод ариутгалын нэг удаагийн цаасан бээлий 43974 хос, гар ариутгагч 508 ширхэг, сонгуулийн ажилтны резин бээлий 2604 хосыг тус тус зарцуулж, ариутгалын бодис 30 ширхэг, сонгогчийн цаасан бээлий 700 хос, сонгуулийн ажилтны резин бээлий 33 хос үлдсэн байна.

Хөрөнгийн зарцуулалтад тавих дотоод хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

2.7 Аймгийн сонгуулийн хороо нь төрийн санд аймгийн 1, сумдын 17 данс нээлгэсэн бөгөөд тухайн дансаар сонгуулийн хорооны санхүүжилт олгож, зардлын зарцуулалтыг олгосон байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 16.2.10¹-д заасны дагуу хэрэгжүүлсэн дотоод хяналтын тайлан мэдээ байхгүй, аудитаар аймаг, сумдын сонгуулийн хороодын санхүүгийн үйл ажиллагаанд алдаа зөрчил илэрч байгаагаас үзэхэд аймгийн сонгуулийн хорооноос сумдын сонгуулийн хорооны зардлын зарцуулалтад тавих хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Улсын төсвөөс олгох санхүүжилтийг СЕХ-оос ирүүлсэн аргачлалын дагуу хуваарилан өмнөх зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан байна.***
- Батлагдсан төсвийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан ч төсвийн зарцуулалтад тавих дотоод хяналтыг сайжруулан ажиллах шаардлагатай байна.***

Аудитаар нийт 25.2 сая төгрөгийн төлбөр зөрчил илэрснээс 1 актаар 0.8 сая төгрөгийн алдаа зөрчилд төлбөрийн акт тогтоож, 11.1 сая төгрөгийн 1 албан шаардлага, 13.3 сая төгрөгийн 4 зөвлөмж өглөө.

Аудитын дүнд илэрсэн зөрчилд үндэслэн дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна.

¹ Сонгуулийн ерөнхий хорооноос хуваарилсан төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу захиран зарцуулах, зохих журмын дагуу харьяалах сонгуулийн хороонд хуваарилах, зарцуулалтад нь хяналт тавих”

ЗӨВЛӨМЖ:

Аймгийн сонгуулийн хорооны дарга Б.Сандагсүрэнд:

- ✚ Сумдын сонгуулийн хороодын санхүүгийн эх үүсвэрээр бэлтгэсэн 6.7 сая төгрөгийн БҮТЭЗ-ийг тухайн сумдын ИТХ-ын данс бүртгэлд тусгуулах
- ✚ Жолоочийн замын хуудсыг тухай бүр хөтөлж зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр “ Авто машины шатахуун зарцуулалтын шинэчилсэн норм” тушаалын холбогдох заалтыг мөрдөх
- ✚ Цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор ирүүлсэн бараа материалын үлдэгдлийг шаардлагатай байгууллагад хүлээлгэн өгөх
- ✚ Аймгийн сонгуулийн хороо сумдын сонгуулийн хорооны зардлын зарцуулалтад тавих хяналтыг хэрэгжүүлж ажиллах.

Аудитаар өгөгдсөн зөвлөмжийн биелэлтийг 2020 оны 12 дугаар сарын 25-ний дотор Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт албан бичгээр ирүүлнэ үү.

ТАЙЛАНТАЙ ТАНИЛЦСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Х.БОЛДБААТАР

ТАЙЛАН ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР:

А.ЦЭЦЭГСҮРЭН

ТАЙЛАН БИЧСЭН:

АХЛАХ АУДИТОР

Д.НАРАНТУУЛ

АХЛАХ АУДИТОР

Д.МӨНХТУЛГА

АУДИТОР

Д.БАЛЖИННЯМ


**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ**

2020 оны 11 сарын 25 өдөр

Дугаар 37

Ховд

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь заалт, Монгол улсын Ерөнхий аудиторовн А/207 дугаар тушаалын 5 дугаар хавсралтын 1.1, 1.3 Монгол Улсын Ерөнхий аудиторовн 2016 оны А/92 тоот тушаалаар баталсан "гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам"-ын 12.40 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1."Аймаг сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг хавсралтаар баталгаажуулсугай.

2.Гүйцэтгэлийн аудитын тайлангаар илэрсэн акт, албан шаардлага, зөвлөмжийг статистик мэдээний маягтын дагуу бүртгэж биелэлтийг тооцон ажиллахыг гүйцэтгэлийн аудитын багийн ахлах аудитор /Д.Нарантуул/-д үүрэг болгосугай.

3. Гүйцэтгэлийн аудитын тайлангийн дүнг, Иргэдийн төлөөлөгчдийн хуралд хүргүүлж аудитын тайланг олон нийтэд танилцуулан сайтад байршуулахыг аудитын багт хариуцуулсугай.

4. Аудитаар өгсөн акт, албан шаардлага зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж үр дүнг 2021 оны 12 дугаар сарын 25-ны дотор танилцуулахыг аймгийн сонгуулийн хорооны нарийн бичиг /Б.Сандагсүрэн/-д зөвлөсүгэй.

5. Аудитын тайланг батлагдсан өдрөөс хойш 14 хонгийн дотор архивын нэгж болгон хүлээлгэн өгөхийг ахлах аудитор /Д.Нарантуул/-д, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер/А.Цэцэгсүрэн/-д тус тус даалгасугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Х.БОЛДБААТАР





**ХОВД АЙМГИЙН
СОНГУУЛИЙН ХОРОО**

84000 Ховд, Ховд аймаг

Утас: 7043-2854 Факс: 676-7043-2854

2020.11.24 № 1/49

талай _____-ны № _____-т

**ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ**

Аймаг, сумын иргэдийн төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх зөвлөмжийг үүгээр зөвшөөрч байна

ДАРГА

Б.САНДАГСҮРЭН